

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ДААТГАЛЫН ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Даатгалын тухай хууль тогтоомж

2.1.Даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2.Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

3.3.Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн эрх зүйн байдлыг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиар зохицуулна.

3.4.Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалтай холбогдсон харилцааг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

3.5.Малын индексжүүлсэн даатгалын харилцааг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулиар зохицуулна.

3.6.Газар тариалангийн даатгалын харилцааг Тариалангийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

3.7.Даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-3.5-д зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “даатгалын үйл ажиллагаа” гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;

4.1.2. “ердийн даатгал” гэж нэг хүртэлх жилийн хугацаатайгаар хийгдэх эд хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал болон бусад амьдралын даатгалд тооцогдохгүй даатгалыг;

4.1.3. “амьдралын даатгал” гэж даатгуулагч урт хугацаатай төлбөрийн үүргээ биелүүлэхэд гарч болох эрсдэл эсвэл хүнд болон эдгэшгүй өвчний улмаас хөдөлмөрлөх чадвараа алдах, амь эрсдэх, өндөр наслах тохиолдолд учрах санхүүгийн эрсдэлийг хаах зорилгоор хийлгэх нас барах эсвэл амьд байхад нөхөн төлбөр олгох даатгалыг;

4.1.4. “даатгагч” гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;

4.1.4.а. “ердийн даатгалын компани” гэж энэ хуулийн дагуу ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагчийг;

4.1.4.б. “амьдралын даатгалын компани” гэж энэ хуулийн дагуу амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагчийг;

4.1.5. “даатгуулагч” гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

4.1.6. “даатгалын тохиолдол” гэж даатгалын гэрээнд заасан эрсдэлээс шалтгаалан даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;

4.1.7. “даатгалын хураамж” гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;

4.1.8. “даатгалын нөхөн төлбөр” гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.9. “даатгалын багц дүрэм” гэж энэ хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах зорилгоор гаргаж буй дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлагыг;

4.1.10. “актуарч” гэж даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийг;

4.1.11. “давхар даатгалын үйл ажиллагаа” гэж даатгагчийн даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргийг бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгах даатгалын үйл ажиллагааг;

4.1.12. “гадаадын зохицуулах байгууллага” гэж даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий гадаад улсын байгууллагыг;

4.1.13. “эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84.1-д заасан этгээдийг.

4.1.14. “холбогдох этгээд” гэж даатгагч болон даатгалын үйл ажиллагаа эрхэлж байсан, тэдэнд хувьцааны хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн

этгээд болон Компанийн тухай хуулийн 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг.

4.1.15.“давхар даатгалын компани” гэж энэ хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

4.1.16.“даатгалын төлөөлөгч” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг;

4.1.17.“даатгалын брокер” гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон эрхийн хүрээнд даатгуулагчийг даатгагчтай холбож өгөх, талуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүнийхээ төлөө хөлс, урамшуулал авах эрхтэй, тусгай зөвшөөрөл бүхий этгээдийг;

4.1.18.“хамтарсан даатгал” гэж нэг эрсдэлийг хэд хэдэн даатгагч хамтран даатгах даатгалын үйл ажиллагааг;

4.1.19.“толгой даатгагч” гэж хамтарсан даатгалын эрсдэлийг хамтран даатгах саналыг бусад даатгагчид тавьж, хамтарсан даатгалын гэрээнд эрсдэлийн тодорхой хувийг хүлээн авахаас гадна зохион байгуулалтын үүрэг хүлээх даатгагчийг;

4.1.20.“хамтарсан даатгалын брокер” гэж хамтарсан даатгалын эрсдэлийг хамтран даатгах саналыг даатгагчдад тавьж, хамтарсан даатгалын үйл ажиллагаанд зохион байгуулалтын үүрэгтэйгээр оролцож байгаа даатгалын брокерийг;

4.1.21.“мэдээлэх хуудас” гэж тухайн даатгалын бүтээгдэхүүний ерөнхий нөхцөл, даатгалын зүйл болон даатгалын тохиолдолтой холбоотой шаардлага, нөхөн төлбөр гаргуулах нөхцөлийг даатгуулагчид таниулахаар бэлтгэсэн хураангуй баримтыг;

4.1.22.“даатгалын хохирол үнэлэгч” гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий, даатгалын хохирлын үнэлгээний байгууллагын гишүүнчлэлтэй этгээдийг;

4.1.23.“цахим даатгалын үйл ажиллагаа” гэж даатгагчаас даатгалын бүтээгдэхүүнийг цахим хэлбэрээр санал болгож, даатгалын гэрээг цахим хэлбэрээр байгуулахыг.

4.2.Давхар даатгалын үйл ажиллагаанд энэ хуулийн 4.1.1 дэх заалт нэгэн адил хамаарна.

4.3.Бодит хохирлоос үл хамааран тодорхой итгэлцүүр буюу бусад аргачлалыг ашиглан даатгагчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг томъёогоор дундажлан тооцоолж гаргадаг үйл ажиллагаа энэ хуулийн 4.1.1-д нэгэн адил хамаарна.

5 дугаар зүйл. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний даатгал

5.1.Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, биет бус хөрөнгө, өөрийн болон ажиллагсдын амь нас, эрүүл мэнд, хариуцлага, эдийн бус ашиг сонирхлыг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нөхцөлөөр даатгуулах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Даатгалын ангилал, төрөл, хэлбэр

6 дугаар зүйл. Даатгалын ангилал

- 6.1. Даатгалыг амьдралын даатгал, ердийн даатгал гэж ангилна.
- 6.2. Амьдралын даатгалд дор дурдсан даатгалын гэрээг хамруулна:
 - 6.2.1. даатгуулагч нас барахад нөхөн төлбөр олгох;
 - 6.2.2. даатгуулагч өндөр наслахад нөхөн төлбөр олгох;
 - 6.2.3. даатгуулагч хөдөлмөрийн чадвараа алдахад нөхөн төлбөр олгох;
 - 6.2.4. даатгуулагч эдгэшгүй, хүнд болон урт хугацаанд үүсэн бий болдог өвчний улмаас орлого тасалдахад нөхөн төлбөр олгох;
- 6.3. Хүний амь настай холбоотой доорх даатгалын гэрээг амьдралын даатгалд тооцохгүй:
 - 6.3.1. нэг жил хүртэлх хугацаатай;
 - 6.3.2. гэнэтийн ослоор эсвэл гэрээнд заасан тодорхой өвчин, эмгэгийн улмаас нас барсан.
- 6.4. Энэ хуулийн 6.2-т зааснаас бусад даатгалыг ердийн даатгалд тооцно.

7 дугаар зүйл. Даатгалын төрөл, хэлбэр

- 7.1. Даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн хэлбэртэй байна.
- 7.2. Даатгалын хэлбэр тус бүр нь төрөлтэй байх бөгөөд албан журмын даатгалын төрлийг хуулиар тогтооно.
- 7.3. Албан журмын даатгалын эрсдэл, нөхцөлийн талаархи нарийвчилсан зохицуулалтыг уг даатгалыг тогтоосон хууль эсвэл түүнд нийцүүлэн баталсан Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан журмаар зохицуулна.
- 7.4. Сайн дурын даатгалын төрлийг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.
- 7.5. Төрийн байгууллага, хуулийн этгээдээс үзүүлэх ажил, үйлчилгээний онцлогоос шалтгаалан тодорхой даатгал хийлгэсэн байх нөхцөлийг тавьж болох ба энэ нь сайн дурын даатгалд хамаарна.
- 7.6. Даатгагчийн үйл ажиллагаа нь энэ хуулийн дагуу тодорхойлсон ангилал, хэлбэр, төрлөөс өөр байна гэж үзвэл энэ хуульд нийцүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо даатгагчид даалгаж болно.

8 дугаар зүйл. Даатгалын хураамж

- 8.1. Албан журмын даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлалыг хуульд нийцүүлэн даатгалын багц дүрмээр тогтооно.
- 8.2. Албан журмын даатгалын хураамжийн суурь хэмжээг энэ хуулийн 7.3-т заасан журмаар тогтоож болно.
- 8.3. Албан журмын даатгалын үнэлгээний доод болон дээд хэмжээг уг даатгалыг тогтоосон хууль эсвэл энэ хуулийн 7.3-т заасан журмаар тогтоож болно.
- 8.4. Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг энэ хуулийн 17.2.5-д заасан аргачлалын дагуу даатгагч тогтооно.

9 дүгээр зүйл. Даатгалын нөхөн төлбөр

9.1. Даатгагч нь хууль болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу энэ хуулийн 9.4-т заасан баримтыг үндэслэн даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

9.2. Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд шууд олгож болно.

9.3. Даатгуулагч нас барсны дараа даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын нөхөн төлбөрийг түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.

9.4. Даатгалын нөхөн төлбөрийг дараахь баримтыг үндэслэн олгоно:

9.4.1. нөхөн төлбөр нэхэмжлэгчийн өргөдөл;

9.4.2. даатгалын гэрээнд заасан бол учирсан хохирлын тухай хохирол үнэлэгчийн бичгээр гаргасан дүгнэлт, акт материал;

9.4.3. шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт.

9.5. Даатгалын гэрээнд заасан бол даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг даатгагчид цахим хэлбэрээр гаргаж болно.

10 дугаар зүйл. Даатгалын нөхөн төлбөр олгох үндэслэл

10.1. Даатгагч дараахь үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзаж болно:

10.1.1. даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг зохиомлоор бүрдүүлсэн;

10.1.2. даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

10.1.3. даатгалын гэрээнд зааснаас бусад эрсдэлээс үүдсэн хохирол гарсан;

10.1.4. гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;

10.1.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

10.2. Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр эсвэл даатгуулагчийн зөвшөөрлөөр цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

10.3. Даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалын гэрээний дагуу олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

10.4. Хариуцлагын даатгалын гэрээнээс бусад гэрээнд даатгуулагч нь даатгалын гэрээний нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн авах эрх бүхий этгээдийг дурдаж болох ба даатгалын нөхөн төлбөрийн үлдэх хувийг энэ хуулийн 9.3-т заасны дагуу түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.

11 дүгээр зүйл. Даатгагчийн эрх, үүрэг

11.1. Даатгагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

11.1.1. энэ хуулийн 10.1-д заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;

11.1.2. даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;

11.1.3.даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

11.1.4.даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

11.1.5.даатгалын гэрээний мэдээлэх хуудсыг гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчид бичгээр эсвэл цахим хэлбэрээр олгох;

11.1.6.даатгалын баталгааг гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид олгох;

11.1.7.даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;

11.1.8.Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;

11.1.9.даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;

11.1.10.даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;

11.1.11.гэрээний хугацаанд даатгуулагч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдвол түүний эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

11.1.12.энэ хуулийн 58 63.2дугаар зүйлд заасан санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх;

11.1.13.даатгалын төлөөлөгч болон зуучлагчаас бусад этгээдэд даатгалын борлуулалтын хөлс, орлогын шимтгэл, урамшуулал олгохгүй байх;

11.1.14.томилсон буюу эрх олгосон даатгалын төлөөлөгчийг Санхүүгийн Зохицуулах хороонд бүртгүүлэх;

11.1.15.эрх олгосон даатгалын төлөөлөгчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг хариуцах.

12 дугаар зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг

12.1.Даатгуулагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

12.1.1.даатгагчаа чөлөөтэй сонгох;

12.1.2.даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

12.1.3.даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

12.1.4.даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;

12.1.5.даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгагчид төлөх;

12.1.6.даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх;

12.1.7.даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;

12.1.8.даатгуулагч болон түүний эрх бүхий этгээд нь нөхөн төлбөрөөс өөр аливаа хөлс, урамшууллыг шууд болон бусад этгээдээр дамжуулан авахгүй байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагааг төрөөс зохицуулах

13 дугаар зүйл. Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

13.1.Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.даатгалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

13.1.2.Засгийн газрыг даатгалын бодлогын зөвлөгөөгөөр хангах;

13.1.3.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

14 дүгээр зүйл. Даатгалын зохицуулах байгууллага

14.1.Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ хэрэгжүүлнэ.

14¹ дүгээр зүйл. Албан журмын даатгалын сан

14¹.1.Албан журмын даатгалын санг бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг албан журмын даатгалын хэлбэрийг тогтоосон хуулиар зохицуулна.

14¹.2. Албан журмын даатгалын сан нь хуульд нийцсэн, Зохицуулах хорооноос зөвшөөрсөн дүрэмтэй байна. Сангийн дүрмийг тухайн сангийн Удирдах зөвлөл батална.

14¹.3. Сангийн дүрэмд дараах асуудлыг тусгана:

14¹.3.1. Сангийн оноосон нэр, хаяг, холбоо барих мэдээлэл;

14¹.3.2. Сангийн Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, Зохицуулах хороонд танилцуулж, батлуулах болон Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнийг томилох, нөхөн томилох журам;

14¹.3.3. Сангийн Гүйцэтгэх удирдлагыг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх журам;

14¹.4. Албан журмын даатгалын сан нь үйл ажиллагааны тайланг хагас жил тутам Зохицуулах хороонд хүргүүлэх бөгөөд сангийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн аудитлагдсан тайланг жил бүрийн эхний улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, улирлын санхүүгийн тайланг өөрийн цахим хуудсаар, цахим хуудасгүй бол Зохицуулах хорооны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

15 дугаар зүйл. Албан журмын даатгалын сангийн удирдлага

15.1. Хуульд өөрөөр заагаагүй бол албан журмын даатгалын сангийн эрх барих дээд байгууллага нь тухайн сангийн Удирдах зөвлөл байх бөгөөд сангийн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг Зохицуулах хороо, даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, даатгагч, даатгуулагчийн төлөөллийг оролцуулан Зохицуулах хороо тогтооно.

15.2.Хуульд өөрөөр заагаагүй бол албан журмын даатгалын сангийн онцлог, хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан тухайн сангийн Удирдах зөвлөл, ажлын албыг шинээр байгуулах эсвэл өөр албан журмын даатгалын санг удирдаж байгаа этгээдээр хамт удирдуулах талаарх шийдвэрийг Зохицуулах хороо гаргаж, хэрэгжилтийг хангуулна.

16 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх

16.1.Зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагч, давхар даатгагчийн даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих;

16.1.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

16.1.3.даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;

16.1.4.даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаарх албан ёсны мэдээлэл гаргах;

16.1.5.даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

16.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

16.2.Зохицуулах хороо нь даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсч болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.

17 дугаар зүйл. Даатгалын багц дүрэм

17.1.Даатгалын үйл ажиллагааг Зохицуулах хорооноос баталсан даатгалын багц дүрмээр зохицуулна.

17.2.Даатгалын багц дүрэмд дараахь дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлага, хэмжээ багтана:

17.2.1.даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлт;

17.2.2.даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам;

17.2.3.даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам;

17.2.4.даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага;

17.2.5.даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал;

17.2.6.даатгалын үнэлгээ хийх аргачлал;

17.2.7.даатгагч болон бусад этгээдээс даатгалын мэргэжлийн оролцогчид шууд болон шууд бусаар төлөх төлбөр, хураамжийг тооцох аргачлал;

17.2.8.даатгагчийн аудиторт тавигдах нөхцөл, шаардлага;

17.2.9.актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам;

17.2.10.гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах даатгагчид тавигдах нөхцөл, шаардлага;

17.2.11.Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагчид тавигдах нөхцөл, шаардлага;

17.2.12.даатгагчаас даатгуулагчид төлбөртэйгээр мэдээлэл, баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээ;

17.2.13.даатгагчаас энэ хуульд заасны дагуу тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар;

17.2.14.даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам;

17.2.15.энэ хуульд заасан тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;

17.2.16.даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага;

17.2.17.Зохицуулах хороонд төлөх төлбөр, хураамж;

17.2.18.Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам;

17.2.19.даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл;

17.2.20.даатгалтай холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар;

17.2.21.энэ хуульд заасан мэдээллийг хэвлэн нийтлэх журам;

17.2.22.даатгалын гэрээний мэдээлэх хуудасны загвар;

17.2.23.хамтарсан даатгалын үйл ажиллагааны журам;

17.2.24.цахим хэлбэрээр даатгалын үйл ажиллагаа явуулах журам.

18 дугаар зүйл. Даатгагчийн бизнесийн үйл ажиллагаа явуулах журам

18.1.Зохицуулах хорооноос даатгагчийн үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан журам гаргаж болно.

18.2.Даатгагч энэ хуулийн 18.1-д заасан журмыг заавал дагаж мөрдөх үүргийг хүлээхгүй боловч ийнхүү дагаж мөрдөөгүй нь даатгагчид хариуцлага ногдуулахад түүнийг даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмших тохиромжтой бус этгээд, эсхүл үйл ажиллагаагаа зохистой явуулаагүй гэж үзэх нөхцөл болж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

19 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

19.1.Энэ хуулийн 19.3, 20.1-д зааснаас бусад этгээд Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

19.2.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол энэ хуулийн 19.1-д заасны дагуу Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа явуулсанд тооцно.

19.3.Даатгагчтай гэрээ байгуулан давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд энэ хуулийн 19.1 дэх хэсэг хамаарахгүй.

19.4.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон даатгагч энэ хуулийн 19.1-д заасанчлан даатгалын үйл ажиллагаа явуулах эрхгүй.

19.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

20 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх эрх бүхий этгээд

20.1.Дараахь этгээд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргах эрхтэй:

20.1.1.Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани;

20.1.2.гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан компани.

20.2.Даатгагчид даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг олгохгүй.

20.3.Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээдэд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй бөгөөд уг этгээд нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан буюу эрх бүхий албан тушаалтан байж болохгүй.

21 дүгээр зүйл. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах

21.1.Энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан этгээд нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө Зохицуулах хороонд гаргана.

21.2.Өргөдлийг бичгээр гаргах бөгөөд түүнд эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг зааж, Зохицуулах хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

21.3.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг өргөдөл гаргагчаас шаардаж болно.

22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

22.1.Зохицуулах хороо дараахь шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн үйл ажиллагаа, даатгалын төрөл, хэлбэрээс хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

22.1.1.өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, өргөдөл гаргагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь тус тус даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

22.1.2.өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрлийг олгосны дараа энэ хууль болон даатгалын багц дүрмийг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

22.1.3.тухайн даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд өргөдөл гаргагчийн удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн эх үүсвэр хангалттай гэж үзвэл;

22.1.4.тусгай зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзвэл.

22.2.Зохицуулах хороо даатгагчийн үйл ажиллагааны цар хүрээ, тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрээс хамааран тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг хэдийд ч өөрчлөн тогтоож болно.

22.3.Зохицуулах хороо амьдралын болон ердийн даатгалын үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй.

22.4.Тусгай зөвшөөрлийг бичгээр олгох бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

22.4.1.тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;

22.4.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг;

22.4.3.эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэр;

22.4.4.үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага;

22.4.5.тусгай зөвшөөрлийн дугаар, олгосон огноо;

22.4.6.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга/тэмдэг/;

22.4.7.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй эсэх.

22.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 79, 80 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

23 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах

23.1.Зохицуулах хороо өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн боловч даатгалын тодорхой төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөөгүй бол энэ тухай бичгээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

23.2.Зохицуулах хороо өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

23.3.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

23.3.1.энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангаагүй;

23.3.2.даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг бүрэн ирүүлээгүй;

23.3.3.хуульд заасан бусад үндэслэл.

23.4.Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгосон тухай даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

23.5.Зохицуулах хороо энэ хуулийн 22.1.1-д заасан “тохиромжтой этгээд”-ийг тодорхойлох зааврыг гаргана.

24 дүгээр зүйл. Даатгалын зүйл

24.1.Монгол Улсад оршин суугч хувь хүн, бүртгэлтэй хуулийн этгээд, мөн гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт буй эд хөрөнгө, биет бус хөрөнгө, ажиллагсдын амь нас, эрүүл мэнд болон бусдын өмнө хүлээх хариуцлагаа гагцхүү энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулна.

24.2.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээ байгуулах тохиолдол бүрт Зохицуулах хорооноос зөвшөөрөл авна.

24.3.Энэ хуулийн 24.2-т заасан гэрээ байгуулах зөвшөөрлийг Зохицуулах хороо зөвхөн дараахь тохиолдолд олгоно:

24.3.1.энэ хуулийн 24.1-д заасан даатгагч тухайн даатгалын эрсдэлийг хариуцах чадваргүй;

24.3.2.энэ хуулийн 24.1-д заасан даатгагч эрсдэлийг хариуцах боломжгүй гэж үзэх бусад хүндэтгэх шалтгаан байвал.

24.4.Гадаадын даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулах даатгагчид дараахь тохиолдолд энэ хуулийн 24.3 дахь хэсэг хамаарахгүй:

24.4.1.энэ хуулийн 53.1-д заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөг Зохицуулах хороогоор батлуулсан бол;

24.4.2.энэ хуулийн 53.2-т заасны дагуу тухайн гэрээнд давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага хамаарахгүй байхаар Зохицуулах хорооноос тогтоосон бол.

24.5.Даатгагч дангаар хариуцах боломжгүй гэж үзсэн үнэлгээ бүхий даатгалын хэлцэлд бусад даатгагчтай хамтран оролцож болно.

ТАВДУГААР БҮЛЭГ Даатгагчийн засаглал

25 дугаар зүйл.Даатгагчийн засаглалын тогтолцоо

25.1.Даатгагч нь даатгалын үйл ажиллагааг найдвартай, оновчтой удирдлагаар хангаж, бизнесийн үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээ, цогц байдалд нийцэх үр дүнтэй засаглалын тогтолцоог бий болгоно.

25.2.Даатгагчийн засаглалын тогтолцоонд дотоод хяналт тогтмол хийгддэг байна.

25.3.Даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөл нь даатгагчийн зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, дотоод аудит, андеррайтинг, нөхөн төлбөр, харилцагчийн гомдол шийдвэрлэх, хөрөнгө оруулалт болон шаардлагатай гэж үзвэл аутсорсингийн бодлого, журмыг баталж мөрдүүлнэ.

26 дугаар зүйл.Даатгагчийн бүтэц, зохион байгуулалт

26.1. Даатгагч нь даатгагчийн стратегийн зорилгууд болон үйл ажиллагааг дэмждэг, ойлгомжтой зохион байгуулалтын бүтэцтэй байна.

26.2. Даатгагч нь төлөөлөн удирдах зөвлөлийнхөө дэргэд Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан байнгын аудитын хороо, гүйцэтгэх удирдлагын дэргэд дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын албыг тус тус ажиллуулна.

26.3. Даатгагч нь төлөөлөн удирдах зөвлөлийнхөө дэргэд цалин, урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, ёс зүйн хороо, хөрөнгө оруулалтын хороо, хөрөнгө, эх үүсвэрийн удирдлагын хороо, засаглалын хороо, стратегийн хороо, ил тод байдлын хороо, хүний нөөцийн хороотой байж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт

27 дугаар зүйл. Даатгагч хөрөнгөө шилжүүлэхэд тавих хяналт

27.1. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

27.2. Аливаа этгээд Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран шууд буюу шууд бусаар эзэмших, өмчлөхийг хориглоно.

27.3. Даатгагч өөрийн эзэмшил, өмчлөлд буй энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгийн талаар Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдэл хийхийг хориглоно:

27.3.1. худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөх;

27.3.2. өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийх.

27.4. Даатгагч энэ хуулийн 27.3-т заасан үйлдэл хийх зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зохицуулах хороонд гаргана.

27.5. Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмших, өмчлөхийг хүсэгч нь ийнхүү эзэмших, өмчлөх тохиромжтой этгээд гэж үзсэн тохиолдолд Зохицуулах хороо даатгагчид зөвшөөрөл олгоно.

27.6. Зохицуулах хороо энэ хуулийн 27.5-д заасан зөвшөөрөл олгохдоо шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл, шаардлага тавьж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, төлбөрийн чадвар

28 дугаар зүйл. Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээ

28.1. Даатгалын компанийн дүрмийн сан нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг даатгалын ангилал, давхар даатгалын онцлогийг харгалзан Зохицуулах хороо тогтооно. Дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно.

28.2. Даатгагчийн дүрмийн сан энэ хуулийн 28.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

29 дүгээр зүйл. Даатгалын компанийн хувьцаа

29.1. Даатгалын компанийн гаргасан бүх хувьцааны төлбөрийг мөнгөн хэлбэрээр хийнэ.

29.2. Даатгалын компанид Компанийн тухай хуулийн 44 дүгээр зүйл хамаарахгүй.

30 дугаар зүйл. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

30.1. Даатгагч нь төлбөрийн чадварын дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

30.1.1. даатгалын багц дүрэмд заасан хэмжээнээс багагүй;

30.1.2. энэ хуулийн 30.2-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй.

30.2. Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлтийг энэ хуулийн 30.1.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно.

30.3. Энэ хуулийн 30.2-т заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд хүрэх боломжит хугацааг даатгагчид олгоно.

30.4. Даатгагчийн төлбөрийн чадвар нь энэ хуулийн 30.1-д заасан үзүүлэлтэд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

31 дүгээр зүйл. Даатгалын нөөц сан

31.1. Даатгагч нь гэрээний явцад үүссэн болон үүсч болзошгүй үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын нөөц сан бүрдүүлнэ.

31.2. Даатгалын нөөц сангийн ангилал, зориулалт, хэмжээ, нөөц санг бүрдүүлэх болон хөрөнгө оруулалтад байршуулах нөхцөлийг даатгалын багц дүрмээр тогтооно.

31.3. Энэ хуулийн 31.1-д заасан даатгалын нөөц сангийн хөрөнгийг тусгайлсан дансанд байршуулна. Дансны бүрдүүлэлт, зарцуулалт Зохицуулах хорооны хяналтад байна.

31.4. Даатгагчийн нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ энэ хуулийн 31.2-т заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

31.5. Даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг даатгалын багц дүрэмд зааснаас өөрөөр зарцуулахыг хориглоно.

32 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

32.1.Ногдол ашиг хуваарилсны дараа дараахь нөхцөлийн аль нэг нь үүсэхээр бол хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй:

32.1.1.даатгагчийн дүрмийн сан нь энэ хуулийн 28.1-д заасан хэмжээнд хүрэхгүй;

32.1.2.даатгагчийн төлбөрийн чадвар энэ хуулийн 30.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй;

32.1.3.даатгалын нөөц сан нь энэ хуулийн 31.2-т заасан хэмжээнд хүрэхгүй.

33 дугаар зүйл. Урьдчилгаа болон зээлтэй холбоотой хязгаарлалт

33.1.Даатгагч нь энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

33.1.1.мөнгө зээлүүлэх, өөрийн үнэт цаасыг төлбөрийн баталгаа болгож урьдчилгаа авах;

33.1.2.холбогдох этгээдэд аливаа сангаас зээл олгох;

33.1.3.аливаа этгээдэд барьцаагүй зээл олгох;

33.1.4.холбогдох этгээдийн бусдаас авсан зээлд баталгаа, батлан даалт гаргах.

33.1.5.даатгалын компанийн дүрмийн сангийн болон даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг холбогдох этгээд болон түүний үүсгэн байгуулсан банкинд байршуулах.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан “холбогдох этгээд”-ийг тодорхойлох зааврыг Зохицуулах хороо гаргаж болно.

33.3.Энэ хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу ногдол ашиг хуваарилахад энэ хуулийн 33.1 дэх хэсэг хамаарахгүй.

34 дүгээр зүйл. Даатгагчийн санхүүгийн чадавхид тавих хяналт

34.1.Зохицуулах хороо даатгагчийн санхүүгийн чадавхийг үнэлэх шалгуур тогтоон, шалгалт хийж болно.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасны дагуу тогтоосон шалгуурын тухай Зохицуулах хороо даатгагчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Нягтлан бодох бүртгэл, аудит

35 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

35.1.Даатгагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон даатгалын багц дүрэмд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

35.2.Даатгалын багц дүрэмд өөрөөр заагаагүй бол Зохицуулах хороо даатгагчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэрийг тогтоож болно.

35.3.Санхүүгийн тайлангийн баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т болон даатгалын багц дүрэмд заасан, эсхүл энэ хуулийн 35.2-т заасны дагуу Зохицуулах хорооноос тогтоосон баримт бичгээс бүрдэнэ.

35.4. Даатгагч энэ хуулийн 35.3-т заасан шаардлагыг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлнэ.

35.5. Даатгагчийн хүлээсэн үүрэг, эд хөрөнгийг даатгалын багц дүрэмд заасны дагуу үнэлнэ.

35.6. Даатгагч нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ 6 жилээс доошгүй хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

36 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх

36.1. Даатгагч нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө.

37 дугаар зүйл. Жил бүрийн санхүүгийн тайлан

37.1. Даатгагч нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд дараахь баримт бичгийн хамт Зохицуулах хороонд тушаана:

37.1.1. удирдлагын тайлан;

37.1.2. аудитын дүгнэлт;

37.1.3. амьдралын даатгал эрхэлж буй даатгагчийн хувьд энэ хуулийн 46.1-д заасны дагуу томилсон актуарчийн тайлан;

37.1.4. тухайн санхүүгийн жилд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үйл явдлын тухай тодруулга, тайлбар;

37.1.5. даатгалын багц дүрэмд заасан бусад баримт бичиг.

37.2. Жил бүрийн санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

37.3. Энэ хуулийн 37.1-д заасан тайлан болон бусад баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

38 дугаар зүйл. Улирал тутмын тайлан

38.1. Даатгагч нь улирал тутмын санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд Зохицуулах хороонд тушаана.

38.2. Улирал тутмын санхүүгийн тайлан, холбогдох бусад баримт бичгийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

38.3. Даатгалын багц дүрэмд заасан баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

39 дүгээр зүйл. Аудит

39.1. Даатгагч нь санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор аудиторыг томилно.

39.2. Энэ хуулийн 39.1-д заасан аудитор нь дараахь шаардлагыг хангасан байна:

39.2.1. Аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй;

39.2.2. даатгагчийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрхийг Зохицуулах хорооноос авсан.

39.3.Зохицуулах хороо энэ хуулийн 39.2-т заасан эрх бүхий аудиторын нэрсийн жагсаалт болон түүнд өөрчлөлт орсон тухай бүр даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

39.4.Даатгагч нь аудиторыг аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжоор хангана.

39.5.Даатгагч нь аудиторыг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

40 дүгээр зүйл. Аудитор актуарчийн тооцоог үндэслэх

40.1.Амьдралын даатгалын компанийн аудитор нь аудитын үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий актуарчийн дараахь тооцоог үндэслэж болно:

40.1.1.тухайн санхүүгийн жилийн эцэст даатгалын гэрээнээс үүссэн үүрэг;

40.1.2.тухайн санхүүгийн жилийн туршид тодорхой сангуудтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт гарсан өөрчлөлт.

41 дүгээр зүйл. Аудитын тайлан

41.1.Аудитор нь даатгагчийн санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу даатгагчид хүргүүлнэ.

41.2.Зохицуулах хороо даатгагчийн эд хөрөнгийн чанар, эрсдэлийн сангийн зохистой харьцаа, нягтлан бодох бүртгэл болон хяналтын тогтолцооны зохистой харьцааг тодорхойлох зорилгоор аудитын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас хэдийд ч шаардаж болно.

41.3.Энэ хуулийн 41.2-т заасан тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

42 дугаар зүйл. Аудиторын үүрэг

42.1.Даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар аудитор нь Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

42.1.1.даатгагч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй байгаа;

42.1.2.даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болзошгүй;

42.1.3.даатгагч энэ хуулийн 28-33 дугаар зүйлийг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзвэл;

42.1.4.даатгагч энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг ноцтойгоор зөрчсөн гэж үзвэл.

42.2.Даатгагч аудитортай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл аудитор өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд аудитор нь Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө:

42.2.1.гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

42.2.2.энэ хуулийн 42.1-д заасан дүгнэлт гаргасан тохиолдолд энэ тухай.

42.3.Зохицуулах хороо аудитороос аудитын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, нэмэлт материал шаардаж болно.

42.4.Аудитор болон аудитор байсан этгээд нь энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасан тайлан болон өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

43 дугаар зүйл. Зохицуулах хорооноос аудиторыг томилох

43.1.Даатгагч энэ хуулийн 39.1-д заасны дагуу аудиторыг томилоогүй бол Зохицуулах хороо аудиторыг томилж болно.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасны дагуу томилогдсон аудитор нь даатгагчийн аудиторын энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

44 дүгээр зүйл. Компанийн нэгдлийн гишүүдийн нягтлан бодох бүртгэлийн тайланг шаардах

44.1.Даатгагч нь компанийн нэгдлийн гишүүн бол Зохицуулах хороо даатгагчаас тухайн нэгдлийн гишүүн аль ч этгээдийн санхүүгийн болон компанийн нэгдлийн нэгдсэн тайланг шаардаж болно.

44.2.Зохицуулах хороо энэхүү тайланг даатгагчийн аудитор, эсхүл өөрийн томилсон аудитороор баталгаажуулахыг шаардаж болно.

44.3.Энэ хуулийн 44.1-д заасан компанийн нэгдлийн тайлангийн агуулга, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Актуарч, актуарын хяналт шалгалт, тайлан

45 дугаар зүйл. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох

45.1.Зохицуулах хороо актуарчаар ажиллахад тохирох мэргэжил, дадлага туршлага, ёс зүй бүхий Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг сонгон шалгаруулж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгоно.

45.2.Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох ажиллагааг даатгалын багц дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.

45.3.Зохицуулах хороо энэ хуулийн 45.1-д заасны дагуу эрх авсан актуарчийн нэрсийн жагсаалт, түүний өөрчлөлтийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

46 дугаар зүйл. Актуарчийг томилохтой холбоотой амьдралын даатгалын компанийн эрх хэмжээ

46.1.Амьдралын даатгалын компани нь заавал актуарчтай байх бөгөөд актуарч нь энэ хуулийн 45.1-д заасны дагуу Зохицуулах хорооноос эрх авсан этгээд байна.

46.2.Даатгагч нь өөрийн актуарчийг томилсон болон чөлөөлсөн тухай бүрт Зохицуулах хороонд ажлын 5 хоногт бичгээр мэдэгдэнэ.

46.3.Актуарчаар томилогдсон этгээд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон бол ийнхүү боломжгүй болсноос хойш ажлын 30 хоногийн дотор даатгагч өөр актуарчийг томилно.

47 дугаар зүйл. Актуарчийн дагаж мөрдөх стандарт

47.1.Актуарч нь өөрийн үйл ажиллагаандаа даатгалын багц дүрэмд заасан актуарын стандартыг дагаж мөрдөнө.

48 дугаар зүйл. Актуарын хяналт шалгалт, тайлан

48.1. Амьдралын даатгалын компани нь үйл ажиллагаандаа актуарын хяналт шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа өөрийн актуарчаар хийлгэх үүрэгтэй.

48.2. Энэ хуулийн 48.1-д заасан актуарын хяналт шалгалт нь даатгалын багц дүрэмд заасны дагуу явагдана.

48.3. Зохицуулах хороо даатгагчийн санхүүгийн байдлын талаарх шаардлагатай гэж үзсэн асуудлыг актуарчаар шалгуулах болон актуарын тайлан гаргаж өгөхийг даатгагчаас шаардаж болно.

48.4. Зохицуулах хороо актуарын хяналт шалгалтыг даатгагчийн томилсон, эсхүл өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлж болно.

48.5. Актуарч нь даатгалын багц дүрэмд заасан агуулга, хэлбэрийн дагуу хяналт шалгалтын тайлан бэлтгэнэ.

48.6. Энэ хуулийн 48.3-т заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх болон тайлан бэлтгэхтэй холбогдсон зардлыг даатгагч хариуцна.

49 дүгээр зүйл. Актуарчийн эрх

49.1. Актуарч нь дараахь эрхтэй байна:

49.1.1. актуарын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг шалгах;

49.1.2. даатгагчийн талаарх шаардлагатай мэдээлэл, баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахыг даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, албан хаагчаас шаардах.

49.2. Актуарч нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож, дараахь асуудлаар үг хэлэх эрхтэй:

49.2.1. даатгагчийн санхүүгийн байдал, нөөцийн сан, төлбөрийн чадвар болон даатгагчийн хөрөнгөд нөлөөлж болох бусад асуудлаар;

49.2.2. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд өгсөн актуарын зөвлөгөөний талаар;

49.2.3. актуарын ажиллагаатай холбоотой асуудлаар.

49.3. Актуарч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, дараахь асуудлаар үг хэлэх эрхтэй:

49.3.1. даатгагчийн санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн тайлан;

49.3.2. актуарчийн эрх хэмжээ, чиг үүрэгтэй холбоотой аливаа асуудал.

49.4. Актуарч нь дараахь асуудлыг Зохицуулах хороонд мэдэгдэж болно:

49.4.1. энэ хуулийн 49.1.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг шалгахад даатгагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр актуарчид дэмжлэг үзүүлэхээс татгалзсан, бусад хэлбэрээр саад учруулсан тухай;

49.4.2. даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан, албан хаагч шаардлагатай мэдээлэл баримт бичиг гаргаж өгөх, асуултад хариулахаас татгалзсан тухай.

50 дугаар зүйл. Актуарчийн үүрэг

50.1. Актуарч нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дараахь дүгнэлтийн талаар Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ:

50.1.1. даатгагч нь энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн, эсхүл зөрчсөн байж болзошгүй;

50.1.2.даатгагч хууль тогтоомж зөрчсөн нь даатгуулагчийн эрх ашигт ноцтой нөлөөлнө гэж үзсэн.

50.2.Актуарч нь даатгагчийн дараахь асуудлаар үнэлгээ хийж, зөвлөмж өгөх, шаардлагатай арга хэмжээ авах талаар даатгагчид мэдэгдэх үүрэгтэй:

50.2.1.даатгагчийн даатгалын гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлага;

50.2.2.хөрөнгө, өр төлбөрийн удирдлага;

50.2.3.даатгагчийн хөрөнгө оруулалтын бодлого болон хөрөнгийн үнэлгээ;

50.2.4.даатгагчийн өр төлбөр, хөрөнгийн хүрэлцээ, нөөц сангууд, төлбөрийн чадварын өнөөгийн байдал, хэтийн төлөв;

50.2.5.даатгагчийн актуар эсвэл санхүүгийн нөхцөл байдалтай холбоотойгоор эрсдэлийн үнэлгээ, удирдлагын бодлого, хяналтын талаар;

50.2.6.андеррайтингийн бодлогын зохистой байдлын талаар;

50.2.7.даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөний зохистой байдлын талаар;

50.2.8.даатгалын бүтээгдэхүүний загвар, боловсруулалт;

50.2.9.өгөгдлийн хүрэлцээ, үнэн зөв байдал, чанар, нөөц сангуудын тооцоололтод ашигласан аргачлал, таамаглал;

50.2.10.бусад даатгагчийн санхүүгийн байдал, нөөцийн сан, төлбөрийн чадвар, даатгагч болон даатгуулагчийн ашиг сонирхолд нөлөөлж болох аливаа асуудлаар.

50.3.Актуарч энэ хуулийн 50.2-т заасны дагуу даатгагчид мэдэгдсэн бөгөөд тогтоосон хугацаанд даатгагч ямар нэг арга хэмжээ аваагүй бол энэ тухай Зохицуулах хороонд нэн даруй мэдэгдэнэ.

50.4.Даатгагч актуарчтай байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд актуарч нь Зохицуулах хороонд дараахь асуудлаар мэдээлэл өгнө:

50.4.1.гэрээ цуцалсан буюу чөлөөлөгдсөн тухай, түүний үндэслэлийн талаар;

50.4.2.энэ хуулийн 50.1, 50.3-т заасан мэдээллийн тухай.

50.5.Актуарч болон актуарч байсан этгээд тайлан болон энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан өөрийн зөв гэж үзсэн бусад мэдээллээр Зохицуулах хороог хангасны төлөө түүнийг мэргэжлийн ёс зүйн дүрэм болон хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүнд эрүүгийн болон бусад хариуцлага ногдуулахгүй.

51 дүгээр зүйл. Зохицуулах хороо актуарчийг томилох

51.1. Амьдралын даатгалын компани нь актуарчийг томилоогүй бол Зохицуулах хороо энэ хуулийн 45.1-д заасан актуарын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийг актуарчаар томилно.

51.2.Энэ хуулийн 51.1-д заасны дагуу томилогдсон актуарч нь амьдралын даатгалын компанийн актуарчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

Давхар даатгал

52 дугаар зүйл. Давхар даатгалд даатгуулах

52.1. Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараахь даатгагчид даатгуулж болно:

52.1.1. энэ хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид;

52.1.2. энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын даатгалын компанид.

52.2. Даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргийн 10-аас доошгүй хувийг энэ хуулийн 52.1.1-т заасан даатгагчид даатгуулна.

52.2.1. энэ хуулийн 52.1.1-т заасан давхар даатгагч нь өөрийн төлбөрийн чадварт үндэслэн 52.2-т заасан хувиас багаар давхар даатгал хийж болох бөгөөд уг давхар даатгалын гэрээг байгуулсан нь анхны даатгагч энэ хуулийн шаардлагыг биелүүлсэнд тооцно.

53 дугаар зүйл. Даатгагчийн давхар даатгалын гэрээ

53.1. Даатгагч даатгалын эрсдэлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөг даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороонд хүргүүлнэ.

53.2. Зохицуулах хороо тухайн төрлийн давхар даатгалын гэрээнд энэ хуулийн 53.1-д заасан давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулахад тавигдах шаардлага хамаарахгүй байхаар бичгээр тогтоож болно.

54 дүгээр зүйл. Давхар даатгалын тайлан

54.1. Даатгагч нь давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг тогтоосон хугацаанд гаргаж Зохицуулах хороонд хүргүүлэх бөгөөд тайланд давхар даатгалын гэрээний хуулбарыг хавсаргана.

55 дугаар зүйл. Хамтарсан даатгал

55.1. Хамтарсан даатгалын гэрээнд оролцогч даатгагчдын тоо нь толгой даатгагчийг оролцуулан таваас хэтрэхгүй байна.

55.2. Толгой даатгагч эсвэл хамтарсан даатгалын зуучлагч нь хамтарсан даатгалын үйл ажиллагааг зохион байгуулахаар даатгагчдад санал тавьсан тухайгаа уг саналыг даатгагчдад хүргүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

55.3. Толгой даатгагч эсвэл хамтарсан даатгалын зуучлагч нь хамтарсан даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах ба толгой даатгагч эсвэл хамтарсан даатгалын зуучлагчийн зохион байгуулалтын энэхүү үүрэг нь хамтарсан даатгалын гэрээ дуусгавар болсноор зогсоно.

55.4. Толгой даатгагчид даатгалын зуучлалын жишиг хөлснөөс ихгүй хэмжээгээр зохион байгуулалтын хөлс олгохоор гэрээнд тохиролцож болно.

55.5. Даатгагчид хүлээн авсан эрсдэлийн хэмжээгээр энэ хууль болон даатгалын багц дүрэмд заасан даатгалын нөөц сангуудыг байгуулна.

55.6. Даатгалын тохиолдлын үед даатгагч бүр хүлээн авсан эрсдэлийн хувь хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

55.7. Хамтарсан даатгалын үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг даатгалын багц дүрмээр тогтооно.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Даатгагчийн үүрэг, даатгагчид тавих хязгаарлалт

56 дугаар зүйл. Даатгагч зөвхөн даатгалын үйл ажиллагаа эрхлэх

56.1. Даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ.

56.2. Даатгагчийн эрхлэх даатгалтай холбоотой үйл ажиллагааг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

57 дугаар зүйл. Даатгагч бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх

57.1. Даатгагч үйл ажиллагаагаа Зохицуулах хорооноос хамгийн сүүлд баталсан бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

57.2. Даатгагч бизнес төлөвлөгөөндөө нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтээ хэзээ ч гаргаж болох бөгөөд энэ тухай хүсэлтээ шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөний төслийн хамт Зохицуулах хороонд хүргүүлнэ.

57.3. Зохицуулах хороо хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөг батлах эсэхийг шийдвэрлэнэ.

57.4. Зохицуулах хороо даатгагчийн шинэчлэгдсэн бизнес төлөвлөгөөг батлах эсэх асуудлыг шийдвэрлэх явцдаа даатгагчаас нэмэлт материал шаардаж болно.

58 дугаар зүйл. Амьдралын даатгалын компанийн сан байгуулах, түүнийг зарцуулах

58.1. Амьдралын даатгалын компани нь эрхэлж буй даатгалын төрөл тус бүрт тусгайлсан данс нээж, тусгайлсан сан байгуулна.

58.2. Амьдралын даатгалын компанийн хөтлөх нягтлан бодох бүртгэлийн болон бусад тайланд дараахь үзүүлэлтийг тус тусад нь гаргаж харуулна:

58.2.1. сан тус бүрд хамаарах хөрөнгө;

58.2.2. даатгалын төрөл тус бүрд хамаарах үүрэг.

58.3. Тухайн сангийн хөрөнгийг зөвхөн тухайн төрлийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах бөгөөд сангийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно.

58.4. Дараахь тохиолдолд энэ хуулийн 58.3 дахь хэсэг хамаарахгүй:

58.4.1. тухайн сангийн хөрөнгийн үнэлгээ нь актуарын тооцоогоор тухайн төрлийн даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээс хэтэрч байвал ийнхүү хэтэрсэн хэсэгт;

58.4.2. амьдралын даатгалын компанийн сангийн хөрөнгийг зах зээлийн үнээр нь өөр хөрөнгөөр солиход.

58.5. Энэ хуулийн 58.4.1-д зааснаас бусад тохиолдолд амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд зориулж байгуулсан сангийн хөрөнгийг даатгагчийн өөр үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

58.6. Амьдралын даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхэд амьдралын даатгалын компанийн сангийн хөрөнгийн хэмжээ хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч, түүний хараат болон охин компани ногдол ашиг төлөх болон төлөхөөр зарлахыг хориглоно.

58.7. Амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон компанид энэ хуулийн 58 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

59 дүгээр зүйл. Тодорхойгүй хэлцлээс зайлсхийх

59.1.Энэ хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш даатгагчийн байгуулсан хариуцлагын хэмжээ, эсхүл дээд хэмжээ нь тодорхойгүй даатгалын гэрээ энэ хуулийн 59.2-т зааснаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр бус байна.

59.2.Энэ хуулийн 59.1-д үл хамаарах даатгалын гэрээний төрөл, хэлбэрийг даатгалын багц дүрмээр тогтоож болно.

60 дугаар зүйл. Нэрэнд хяналт тавих буюу “Даатгал” гэсэн нэр томъёог хэрэглэхийг хязгаарлах

60.1.Даатгагч нь оноосон нэртэй байх бөгөөд уг нэрийн ард “даатгал” гэсэн үгийг заавал хэрэглэнэ.

60.2.Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад этгээд “даатгал”, эсхүл “даатгал” гэсэн үгний төрөл үг хэрэглэх, даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл уг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан гэсэн сэтгэгдэл төрүүлэхүйц нэр томъёо ашиглах болон тэдгээртэй адилтгах бусад үйлдэл хийхийг хориглоно.

60.3. даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй компанид энэ хуулийн 60.1 дэх хэсэг хамаарахгүй бөгөөд тэдгээрийн нэр нь зөвхөн тухайн төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг болохыг илэрхийлсэн байвал зохино.

61 дүгээр зүйл. Даатгагчийн ерөнхий захиргааны хаяг

61.1.Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан даатгалын компанийн ерөнхий захиргаа нь Монгол Улсад байрлах бөгөөд даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

61.2.Даатгагч нь ерөнхий захиргааныхаа хаягийг өөрчилбөл ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

62 дугаар зүйл. Салбар, төлөөлөгчийн газар нээх

62.1.Даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулахдаа Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл авна.

62.2.Гадаадын даатгагч Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

62.3.Гадаадын даатгагч Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд гадаадын даатгагчийг төлөөлж дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

62.3.1.даатгалын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан байр нээж ажиллуулах;

62.3.2.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

62.4.Зохицуулах хороо энэ хуулийн 62.1-д заасан зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхдээ нэмэлт мэдээлэл, баримтыг даатгагчаас шаардаж болно.

62.5.Энэ хуулийн 62.2-т заасан зөвшөөрөл олгохдоо Зохицуулах хороо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагаа хэдийд ч өөрчилж болно.

63 дугаар зүйл. Эрх бүхий албан тушаалтныг томилох

63.1. Даатгагч болон энэ хуулийн 14-дүгээр зүйлд заасан Сан нь Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн компани болон Сангийн эрх бүхий албан тушаалтныг томилно.

63.2. Зохицуулах хороо нь тухайн этгээд компанийн уг албан тушаалд боловсрол, мэргэжлийн шаардлага болон ёс зүйн хувьд тохирно гэж үзвэл энэ хуулийн 63.1-д заасан зөвшөөрлийг олгоно.

63.3. Даатгагчийн эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх дуусгавар болсон, шүүхээр буруутай болсон нь тогтоогдсон эсхүл хүсэлтээрээ чөлөөлөгдсөн тохиолдолд даатгагч энэ тухай ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

63.4. Зохицуулах хороо нь 63.2-д заасан этгээдийн ёс зүйн хувьд тохирох эсэхийг тодорхойлохдоо ял шийтгэл эдэлж байсан эсэх, дампуурсан компанийн гүйцэтгэх удирдлагын албан тушаал эрхэлж байсан эсэхийг харгалзаж үзэх ба тус мэдээллийг гаргуулах боломжгүй тохиолдолд тухайн этгээдээс мөнгөн барьцаа байршуулна.

64 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөлгүй даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгч бус этгээдэд төлбөр төлөхийг хориглох

64.1. Даатгагч нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээд болон гэрээ байгуулаагүй даатгалын төлөөлөгчид аливаа төлбөр, хураамж, шимтгэл төлөхийг хориглоно.

65 дугаар зүйл. Мэдээллийг өөрчлөх

65.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч байгаа этгээд, эсхүл даатгагч болон бусад этгээдээс энэ хууль, даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороонд гаргаж буй аливаа зөвшөөрөл хүссэн өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Зохицуулах хороонд ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

66 дугаар зүйл. Даатгагчийн санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх

66.1. Даатгагч энэ хуулийн 37 дугаар зүйл дэх аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан, улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор нийтэд хэвлэлээр болон өөрийн цахим хуудсаар мэдээлж байна.

66.2. Даатгагч өөрийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагын гарын үсгээр баталгаажсан дараахь мэдээллийг ажлын 10 хоногийн дотор өөрийн цахим хуудсанд байршуулах замаар нийтэд мэдээлнэ:

66.2.1. даатгагчийн жилийн үйл ажиллагааны тайлан;

66.2.2. даатгагчийн компанийн засаглалын тайлан;

66.2.3. Зохицуулах хорооноос даатгагчийн эрсдэлийг тодорхойлоход шаардлагатай гэж үзсэн, нийтэд мэдээлэхээр зохицуулсан бусад мэдээлэл.

66.3. Даатгагч нь дараахь мэдээллийг өөрийн цахим хуудсандаа тогтмол байршуулж, олон нийтэд мэдээлнэ:

66.3.1. хуулийн этгээдийн эрх зүйн хэлбэр, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн;

66.3.2. зохион байгуулалтын болон засаглалын тогтолцооны бүтэц;

66.3.3. санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын тогтолцоо;

66.3.4. нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын овог нэр, мэргэжил, мэргэшсэн байдал, ажлын туршлагын талаарх мэдээлэл;

66.3.5. хамтран ажилладаг давхар даатгалын компаниудын мэдээлэл;

66.4. Зохицуулах хороо нь даатгагчийн олон нийтэд мэдээлсэн тайлан, мэдээллийн үнэн, зөв байдалд хяналт тавьж, зохицуулж ажиллана.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Зах зээлийн ёс зүй

67 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

67.1. Даатгагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

67.2. Даатгалын бүтээгдэхүүнийг шударгаар сурталчлах үүднээс даатгагчийн олон нийтэд даатгалын бүтээгдэхүүний талаар өгөх мэдээлэл нь дараахь шаардлагыг хангасан байна:

67.2.1. хялбар ойлгогдохуйц;

67.2.2. бүтээгдэхүүнийг санал болгож буй даатгагчийг тодорхой заасан;

67.2.3. санал болгож буй даатгалын хамгаалалттай нийцсэн;

67.2.4. тухайн бүтээгдэхүүнээс даатгалын гэрээ эзэмшигчийн зүй ёсоор хүлээж буй үр дүнтэй нийцсэн;

67.2.5. чухал мэдээлэл эсвэл анхааруулгыг нуух, бууруулах эсвэл бүрхэгдүүлээгүй байх.

67.3. Даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

68 дугаар зүйл. Зах зээлийн ёс зүй

68.1. Зохицуулах хороо даатгагчийн дагаж мөрдвөл зохих зах зээлийн ёс зүйн журмыг гаргаж болох бөгөөд даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон даатгалын үйл ажиллагаанд оролцогч түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

68.2. Даатгагч нь даатгуулагч болон түүний эрх бүхий этгээдэд нөхөн төлбөр олгохоос бусад тохиолдолд аливаа төлбөр, хураамжийг шууд болон бусад этгээдээр дамжуулан олгохгүй байх үүрэгтэй.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах

69 дүгээр зүйл. Үйл ажиллагааны шалгалтад хамаарах холбогдох этгээд

69.1.Энэ хуулийн арвангуравдугаар бүлэгт заасан “холбогдох этгээд” гэдэгт даатгагч болон даатгагч байсан этгээд, эсхүл түүний хараат болон охин компани хамаарна.

70 дугаар зүйл. Холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалт

70.1.Зохицуулах хороо холбогдох этгээдийн үйл ажиллагааг энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шалгах зорилгоор дараахь арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлж болно:

70.1.1.холбогдох этгээдийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, баримт бичгийг шалгах;

70.1.2.холбогдох этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, бэлэн мөнгө зэргийг шалгах, тоолох;

70.1.3.холбогдох этгээдийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлан авч хянаж шалгах.

70.2.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдэд хяналт тавихтай холбоотой дараахь асуудлыг судлан үзэж болно:

70.2.1.нөөцийн сан, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон хөрөнгийг шалгах;

70.2.2.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэм болон Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлж байгаа эсэх.

70.3.Зохицуулах хороо үйл ажиллагааны шалгалтын удирдамжийг холбогдох этгээдэд урьдчилан танилцуулна.

70.4.Зохицуулах хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн холбоо болон тохирох дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

70.5.Үйл ажиллагааны шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа холбогдох этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулна.

71 дүгээр зүйл. Үйл ажиллагааны шалгалттай холбоотой холбогдох этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

71.1.Холбогдох этгээд үйл ажиллагааны шалгалтын үед дараахь үүрэг хүлээнэ:

71.1.1.өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

71.1.2.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

71.1.3.шаардлагатай мэдээлэл, тайлбараар хангах;

71.1.4.шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс олж авч Зохицуулах хороонд өгөх.

71.2.Зохицуулах хороо шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгөхийг холбогдох этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас бичгээр шаардаж болно.

72 дугаар зүйл. Шалгалтын тайлан

72.1.Зохицуулах хороо нь үйл ажиллагааны шалгалт дууссанаас хойш ажлын 45 хоногийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлнэ.

72.2.Шалгалтын тайланд дараахь зүйлийг тусгана:

72.2.1.холбогдох этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаарх зөвлөмж;

72.2.2.тайлантай холбогдуулан холбогдох этгээдээс хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзэж буй асуудлын талаар.

72.3.Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол холбогдох этгээд тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Зохицуулах хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

73 дугаар зүйл. Зохицуулах хорооны мэдээлэл цуглуулах эрх

73.1.Зохицуулах хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 73.2-т заасан этгээдээс дараахь зүйлийг бичгээр шаардаж болно:

73.1.1.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл гаргаж өгөхийг;

73.1.2.тодорхой төрлийн буюу тусгайлан заасан баримт бичиг гаргаж өгөхийг.

73.2.Энэ хуулийн 73.1-д заасан мэдэгдлийг холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээд, даатгагч, эсхүл мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн этгээдэд өгөх бөгөөд мэдэгдэлд мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх буюу үйлдэх хугацаа, газрыг заана.

73.3.Энэ хуулийн 73.2-т заасан “холбоотой этгээд”-ийг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

73.4.Зохицуулах хороо энэ хуулийн 73.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь шаардлагыг тавьж болно:

73.4.1.тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

73.4.2.уг мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

73.4.3.уг мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

73.5.Зохицуулах хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

73.6.Зохицуулах хорооноос энэ хуулийн 73.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.

74 дүгээр зүйл. Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх

74.1.Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг бичгээр хүссэн тохиолдолд Зохицуулах хороо энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох, мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

74.2.Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, бичиг баримтаар хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараахь асуудлыг анхаарна:

74.2.1.Гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

74.2.2.Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх;

74.2.3. асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач холбогдолтой эсэх;

74.2.4. мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлсөн эсэх;

74.2.5. энэ хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

74.3. Зохицуулах хороо гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

74.4. Гадаадын зохицуулах байгууллага энэ хуулийн 74.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлээгүй бол Зохицуулах хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Албадлагын арга хэмжээ

75 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

75.1. Зохицуулах хороо дараахь үндэслэлээр даатгагчид албадлагын арга хэмжээ авч болно:

75.1.1. энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол;

75.1.2. даатгуулагчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

75.1.3. даатгагч төлбөрийн чадваргүй болсон буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзвэл;

75.1.4. Зохицуулах хорооноос энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

75.1.5. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

75.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

75.1.7. даатгагч татан буугдсан;

75.1.8. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүй;

75.1.9. даатгалын үйл ажиллагааг зохистой явуулаагүй;

75.1.10. холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Зохицуулах хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

75.1.11. даатгалын эрсдэлээ хязгаарлах зорилгоор давхар даатгалын төлөвлөгөө хийгээгүй, эсхүл давхар даатгалын төлөвлөгөө нь даатгалын багц дүрэмд заасан шаардлага хангахгүй;

75.1.12. бизнес төлөвлөгөөг дагаж мөрдөөгүй буюу хамгийн сүүлд баталсан бизнес төлөвлөгөөг ноцтойгоор зөрчсөн;

75.1.13. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

76 дугаар зүйл. Албадлагын арга хэмжээний төрөл

76.1. Зохицуулах хороо энэ хуулийн 75.1-д заасан үндэслэлээр дараахь төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

76.1.1.энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу урьдчилан сэргийлэх болон засан залруулах арга хэмжээ авах;

76.1.2.даатгалын үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэн томилох;

76.1.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

76.1.4.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

76.1.5.энэ хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу шалгагч томилох;

76.2.Зохицуулах хороо энэ зүйлд заасан албадлагын арга хэмжээг авахдаа зөрчил, дутагдал, үүссэн нөхцөл байдалд тохирч, дүйцсэн арга хэмжээ авах зарчмыг баримтална.

76.3.Энэ хуульд заасан арга хэмжээг авсан нь энэ хууль, бусад хууль тогтоомжоор Зохицуулах хорооноос арга хэмжээ авах, хариуцлага ногдуулах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

77 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх болон засан залруулах арга хэмжээ авах

77.1.Зохицуулах хороо даатгагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараахь агуулга бүхий даалгаврыг өгч болно:

77.1.1.болзошгүй зөрчил, дутагдлын талаар албан анхааруулга өгөх;

77.1.2.зөрчил, дутагдлыг арилгах талаар албан сануулга өгөх;

77.1.3.зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх, төлөвлөгөө гаргуулах;

77.1.4.төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтүүдийг тогтоосон түвшинд хүргэх талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх, төлөвлөгөө гаргуулах;

77.1.5.даатгагчийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах, төлөвлөгөө гаргуулах;

77.1.6.даатгагчийн өөрийн хөрөнгийг тогтоосон хугацаанд нэмэгдүүлэхийг шаардах, төлөвлөгөө гаргуулах;

77.1.7.тодорхой эрсдэлүүдийг бууруулах эсвэл багасгах арга хэмжээнүүдийг авахыг даалгах, төлөвлөгөө гаргуулах;

77.1.8.хөрөнгө шилжүүлэхийг хязгаарлах;

77.1.9.даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

77.1.10.даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэртэй холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

77.1.11.байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох;

77.1.12.даатгалын нийт хураамжийн хэмжээг даалгаварт заасан хэмжээгээр тогтоох;

77.1.13.тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахыг хориглох;

77.1.14.тодорхой хугацааны дотор өөрийн эзэмшилд буй хөрөнгө оруулалтыг чөлөөлөх;

77.1.15.хуульд заасан хугацаанаас өмнө санхүүгийн хяналт шалгалт хийх, шалгалттай холбогдуулан актуарч болон бусад этгээдийг томилох;

77.1.16.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэмд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх;

77.1.17.бизнес төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

77.1.18.даатгуулагч болон хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

77.1.19.даатгагчийн гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, чөлөөлөх;

77.1.20.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, чөлөөлөх;

77.1.21.энэ хуулийн 77.1.1-77.1.20-д заасан арга хэмжээг даатгагч биелүүлээгүй бол нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн саналын эрхийг түдгэлзүүлэх.

77.2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон бол шаардлагатай гэж үзсэн бусад даалгаврыг өгч болно.

77.3.Зохицуулах хороо энэ зүйлд заасан хэд хэдэн арга хэмжээг даатгагчид нэгэн зэрэг авч хэрэгжүүлж болно.

77.4.Энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгагч биелүүлэх үүрэгтэй.

77.5.Зохицуулах хороо нь авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд үнэлгээ хийсний үндсэн дээр даатгагчид тогтоосон шаардлага, хязгаарлалт, хориглолтыг хэсэгчлэн болон бүрэн цуцлах, хэвээр үлдээх, өөр эсвэл дараагийн шатны арга хэмжээг авах зарчмыг баримтална.

77.6.Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон этгээдэд энэ хуулийн 77 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

78 дугаар зүйл. Шалгагчийг томилох

78.1.Зохицуулах хороо энэ хуулийн 75.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

78.2.Энэ хуулийн 78.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараахь асуудлыг хянан шалгаж болно:

78.2.1.даатгагчийн үйл ажиллагаа, түүний шинж чанар;

78.2.2.даатгагчийн үйл ажиллагааны тодорхой асуудлууд;

78.2.3.даатгагчийн болон хувьцаа эзэмшигчдийн хяналт.

78.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагааг хэдийд ч шалгаж болно.

78.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Зохицуулах хороо өөрийн үзэмжээр тогтооно.

79 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

79.1.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлнэ:

79.1.1.энэ хуулийн 75.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

79.1.2.тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

79.1.3.тусгай зөвшөөрлийн жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

79.2.Тусгай зөвшөөрлийг дараахь хугацаагаар түдгэлзүүлнэ:

79.2.1.Зохицуулах хорооноос тогтоосон хугацаагаар;

79.2.2.Зохицуулах хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

79.3.Энэ хуулийн 79.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

79.4.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс хойш энэ хуулийн 79.2.2-т заасан шаардлагыг 6 сарын дотор биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

79.5.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

79.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 79.5-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

79.7.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

79.7.1.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

79.7.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, түдгэлзүүлж эхэлсэн огноо;

79.7.3.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

79.8.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай мэдэгдэл авсанаас хойш байгуулагдсан даатгалын гэрээ хүчин төгөлдөр бус байна.

80 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

80.1.Зохицуулах хороо дараахь үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

80.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

80.1.2.даатгалын компани татан буугдсан;

80.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

80.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

80.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

80.2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

80.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

80.4.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

80.4.1.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

80.4.2. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл, огноо.

80.5. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ажилладаг даатгалын зуучлагч байгууллагуудад мэдээлнэ.

81 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

81.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш даатгагч Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдэл хийхийг хориглоно:

81.1.1. шинээр даатгалын гэрээ байгуулах;

81.1.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан даатгалын гэрээг сунгах, шинэчлэх, өөрчлөх.

81.2. Шаардлагатай гэж үзвэл даатгагч нь даатгалын гэрээгээр хүлээсэн үүрэг, давхар даатгалын хураамжийн төлбөр болон гэрээнээс үүссэн бусад зардлыг төлөх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

81.3. Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаархи мэдээллийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

82 дугаар зүйл. Зохицуулах хороо даатгагчийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

82.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 79.1, 80.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл нийтийн болон зээлдүүлэгч, даатгуулагчийн ашиг сонирхол, даатгагчийн өмч хөрөнгө, үйл ажиллагааг хамгаалах зорилгоор Зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

82.2. Зохицуулах хороо энэ хуулийн 82.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа даатгагчид мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

82.3. Даатгагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй бол нэхэмжлэлийг энэ хуулийн 79.2, 80.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай мэдэгдлийг даатгагчид өгөхөөс өмнө гаргаж болно.

82.4. Энэ хуулийн 82.1-д заасан нэхэмжлэлийн дагуу шүүх дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

82.4.1. даатгагч болон бусад этгээдийн эзэмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

82.4.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө даатгагчийн үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг нэн даруй томилох;

82.4.3. компанийг татан буулгах;

82.4.4. даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

82.5. Шүүх энэ хуулийн 82.4.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Зохицуулах хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

82.6. Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талаар дараахь арга хэмжээг хэдийд ч авч болно:

82.6.1.эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

82.6.2.эрх хэмжээг нь өөрчлөх;

82.6.3.бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх

83 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх зөвшөөрөл

83.1.Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа өөр даатгагчид шилжүүлэх болон нэгтгэх хүсэлтээ Зохицуулах хороонд гаргаж бичгээр зөвшөөрөл авна.

83.2.Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд даатгагчид дараахь зүйлийг хориглоно:

83.2.1.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг өөр даатгагчид шилжүүлэх;

83.2.2.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг өөр даатгагчийн үйл ажиллагаатай нэгтгэх.

83.3.Энэ хуулийн 83 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэх болон нэгтгэх тухай өргөдөл гаргах, өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагаа, шилжүүлэх болон нэгтгэх үйл ажиллагааг даатгалын багц дүрмээр нарийвчлан зохицуулна.

83.4.Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх тухай хүсэлт гаргахдаа бүрдүүлэх бичиг баримтад дараахь бичиг баримт заавал байна:

83.4.1.холбогдох актуарын тайлан;

83.4.2.шилжүүлэх болон нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө;

83.4.3.шилжүүлэх болон нэгтгэх үйл ажиллагаа хэрэгжиж дууссаны дараахь байдлаар тооцоолсон шилжүүлж байгаа болон нэгтгэн авч байгаа даатгагчийн төлбөрийн чадвар, нөөц сан болон санхүүгийн бусад гол үзүүлэлтүүд;

83.4.4.шилжүүлж буюу нэгтгэж байгаа үйл ажиллагаанд хамаарах даатгалын гэрээ эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тухай санал, төлөвлөгөө.

83.5.Шилжүүлэх болон нэгтгэх тухай зөвшөөрлийг олгохоос өмнө Зохицуулах хороо дараахь арга хэмжээг авч болно:

83.5.1.шилжүүлэх болон нэгтгэх нь зохимжтой эсэх талаар судлах;

83.5.2.даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай гэж үзсэн баримт бичиг, мэдээллийг шаардаж авах.

83.6.Зохицуулах хороо нь шаардлагатай гэж үзвэл даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлж байгаа даатгагч эсвэл даатгалын үйл ажиллагааг нэгтгэн авч байгаа даатгагч, эсвэл хоёуланд нь тус бүрт хамаарах тодорхой нөхцөлүүдийн үндсэн дээр даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх тухай зөвшөөрлийг олгож болно.

83.7.Энэ хуулийн 83.5.1-д заасныг Зохицуулах хороо буюу түүний эрх олгосон этгээд хэрэгжүүлэх бөгөөд зардлыг даатгагч хариуцна.

83.8.Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх, эсхүл бусдын үйл ажиллагаатай нэгтгэх үр дагавар бүхий даатгагчийн байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

83.9. Зохицуулах хороо нь даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх тухай гаргасан өргөдлийг нээлттэй хурлаар хэлэлцэж болох бөгөөд даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай нотлох баримт шаардаж болно.

83.10. Зохицуулах хороо дараахь тохиолдлуудад даатгагчид даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэхийг зөвшөөрөхгүй:

83.10.1. шилжүүлэх эсвэл нэгтгэх нь даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлж байгаа даатгагчийн эсвэл нэгтгэн авч байгаа даатгагчийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзвэл;

83.10.2. даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлж байгаа даатгагчийн эсвэл нэгтгэн авч байгаа даатгагчийн даатгалын гэрээ эзэмшигч эсвэл даатгуулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байвал;

83.10.3. даатгалын зах зээлд шударга бус өрсөлдөөнийг бий болгож болзошгүй бол;

83.10.4. ашиг сонирхлын ноцтой гэж үзэж болох зөрчил үүсэхээр байвал;

83.10.5. Энэ хуулийн 83.6-д заасан нөхцөлийг даатгалын үйл ажиллагааг шилжүүлж байгаа эсвэл нэгтгэн авч байгаа даатгагчийн аль нэг нь зөвшөөрөөгүй бол.

84 дүгээр зүйл. Даатгалын гэрээ шинээр байгуулахыг хориглох

84.1. Энэ хуулийн 83.1-д заасны дагуу даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх хүсэлтээ гаргасан өдрөөс эхлэн уг хүсэлтийг гаргасан даатгагчид ижил төрлийн даатгалын үйл ажиллагааг хориглох буюу ижил төрлийн даатгалын гэрээг шинээр байгуулахыг хориглоно.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Даатгагчийг татан буулгах

85 дугаар зүйл. Даатгагчийн дампуурал

85.1. Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Дампуурлын тухай хуулийн дагуу зохицуулна.

85.2. Шүүх дараахь асуудлын талаар Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо уг асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй:

85.2.1. Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгүүлэх тухай шүүхэд гаргасан нэхэмжлэл болон хүсэлт;

85.2.2. Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгэсэнтэй холбоотой гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргаж буй аливаа гомдол;

85.2.3. даатгагчийн дампууралтай холбоотой Дампуурлын тухай хуулийн дагуу шүүхээс шийдвэрлэж буй бусад асуудал.

85.3. Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан тохиолдолд Зохицуулах хороо Дампуурлын тухай хуулийн 5.7-д заасан хэрэг гүйцэтгэгчийг түр томилуулахаар хүсэлт гаргаж болох бөгөөд түүнд тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг санал болгож болно.

85.4. Даатгагч дампуурсан тухайгаа зарласан тохиолдолд Зохицуулах хороо тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг хэрэг гүйцэтгэгчээр

томилуулахаар шүүхэд санал тавих бөгөөд энэ тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 8.2 дахь хэсэг үйлчлэхгүй.

85.5.Шүүх Зохицуулах хорооноос санал болгосон этгээдийг хэрэг гүйцэтгэгчээр томилж болно.

85.6.Хэрэг гүйцэтгэгч болон хэрэг гүйцэтгэгчээр түр томилогдсон этгээд нь Дампуурлын тухай хуулийн 11.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна даатгалын компанийн үйл ажиллагааны онцлогийн талаар зохих мэдлэгтэй байна.

85.7.Зохицуулах хороо нь Дампуурлын тухай хуулийн 8.3.3, 8.3.4, 8.3.6-д заасан асуудлаар шийдвэр гаргах эрхтэй.

85.8.Хэрэг гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааны тухай Зохицуулах хорооны шаардлагатай гэж үзсэн мэдээлэл, тайланг гаргаж өгөх үүрэгтэй.

85.9.Зохицуулах хороо хариуцагч болон хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар шүүхэд хэдийд ч гомдол гаргах эрхтэй.

85.10.Хариуцагч нь даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Дампуурлын тухай хуульд заасан аливаа хугацааг шүүх өөрийн үзэмжээр сунгах эрхтэй.

86 дугаар зүйл. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх

86.1.Дампуурлын тухай хуулийн 23.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж байгаа, мөн хуулийн 24.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүхэд гаргаж буй этгээд нь уг хүсэлт, төлөвлөгөөний хуулбарыг Зохицуулах хороонд хүргүүлнэ.

86.2.Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж буй нэхэмжлэгчдийн хуралд Зохицуулах хороо оролцож саналаа илэрхийлэх эрхтэй.

86.3.Шүүх даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр батлахгүй.

86.4.Шүүхээс даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах үйл ажиллагаанд Дампуурлын тухай хуулийн 28 дугаар зүйл үйлчлэхгүй.

87 дугаар зүйл. Даатгагчийг татан буулгах

87.1.Даатгагчийг татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

87.2.Даатгагчийг дараахь тохиолдолд татан буулгана:

87.2.1.шүүхийн шийдвэрээр;

87.2.2.Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр.

87.3.Даатгагчийг татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр нь Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хүчин төгөлдөр бус байна.

87.4.Энэ хуулийн 87.2-т зааснаас бусад тохиолдолд даатгагчийг татан буулгасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

87.5.Дараахь тохиолдолд Зохицуулах хороо даатгалын компанийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

87.5.1.даатгалын компани төлбөрийн чадваргүй болсон;

87.5.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

87.6.Зохицуулах хороо тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хуулийн этгээдийг татан буулгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

87.7.Даатгагчийг татан буулгахаар нэхэмжлэл гаргасан тухай шүүх Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо нэхэмжлэлтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй.

87.8.Дампуурлын тухай хуулийн дагуу даатгагчийг татан буулгахад шүүх хяналт тавих бөгөөд Дампуурлын тухай хуулийн 38.1 дэх хэсэг үйлчлэхгүй.

88 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах

88.1.Энэ хуулийн 87.2.2-т заасны дагуу гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах тухай өргөдөлд татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээдийн нэрсийн жагсаалтыг хавсаргана.

88.2.Зохицуулах хороо хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах зөвшөөрлийг дараахь тохиолдолд олгохгүй:

88.2.1.даатгагчийн хөрөнгийн нийт үнэлгээнээс түүний хүлээсэн үүргийг хасаж үлдсэн хэсэг нь энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн доод хэмжээг хангахгүй;

88.2.2.татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай ур чадвар, дадлага туршлагагүй.

88.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлаас даатгагчийг татан буулгах тухай тогтоолыг батлахдаа татан буулгах комиссыг томилно.

88.4.Татан буулгах комисс томилогдсон тухайгаа тогтоолд заасан хугацаанд Зохицуулах хороонд мэдэгдэх үүрэгтэй.

88.5.Татан буулгах комиссын эрх хэмжээг Зохицуулах хорооноос холбогдох хуульд нийцүүлэн тогтооно.

89 дүгээр зүйл. Амьдралын даатгалын компанийн урт хугацааны сан

89.1. Амьдралын даатгалын компани нь удаан хугацаагаар тогтвортой үйл ажиллагаа эрхлэх үүднээс урт хугацааны сан бүрдүүлнэ.

89.2. Амьдралын даатгалын компани нь Дампуурлын тухай хууль болон бусад хуулийн дагуу татан буугдахад даатгагчийн урт хугацааны санг зөвхөн энэ хуулийн 89 дүгээр зүйлд заасны дагуу зарцуулна.

89.3.Даатгагчийн урт хугацааны сан нь тус санд хамаарах даатгагчийн урт хугацаат үүргийн гүйцэтгэлийг хангахад зарцуулагдах бөгөөд энэ хэмжээгээрээ даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцогдохгүй.

89.4.Энэ хуулийн 89.3-т заасны дагуу зарцуулсны дараа үлдсэн хөрөнгийг Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцож болно.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад

90 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

90.1.Зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ

хэрэгжүүлэхдээ дараахь этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

90.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

90.1.2.даатгагч, эсхүл даатгагч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

90.1.3.даатгуулагч, эсхүл даатгуулагч байсан этгээд.

90.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 90.1 дэх хэсэг хамаарахгүй:

90.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

90.2.2.Зохицуулах хороо шаардсан;

90.2.3.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

90.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

90.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

90.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 90.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

90.2.7.энэ хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

91 дүгээр зүйл. Зохицуулах хорооны шийдвэрт гомдол гаргах

91.1.Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд хандаж болно.

91.2.Зохицуулах хорооны шийдвэрт гомдол гаргасан нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

91¹. дүгээр зүйл. Маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх

91¹.1.Арбитрын хэлэлцээртэй бол даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

91¹.1.Энэ хуулийн 91¹.1-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 91 дүгээр зүйл хамаарахгүй.

92 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

92.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

92.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

93 дугаар зүйл. Зохицуулах хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

93.1.Зохицуулах хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын багц дүрэмд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

94 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

94.1.Энэ хуулийг 20... оны ...дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ